



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/97

Есөнбулаг сум

Эрх шилжүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь заалт, Прокурорын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 03-ний өдрийн 64 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 200.000.000 (Хоёр зуун сая) төгрөгийн хөрөнгө оруулалтаар төрийн байгууллагыг инженерийн шугам сүлжээнд холбох ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гүйцэтгүүлэх эрхийг Прокурорын газар (Н.Цогтбаяр)-т шилжүүлсүгэй.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, шаардлага хангасан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Прокурорын газар (Н.Цогтбаяр)-т үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилт, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Д.Чинзориг), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

